СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМААС БИЧИГТ БООМТЫН ТӨВ ЗАМ ХҮРТЭЛХ 136.9 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр №26-02 Улаанбаатар хот

1.Танилцуулга

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр баталсан ажлын даалгаврын хүрээнд, "Кеаро" ХХК-ийн боловсруулсан, Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх 136.9 км хатуу хучилттай авто замын нарийвчилсан зураг төсөлд замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх, хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний үүргийн хүрээнд 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс мөн оны 01 дүгээр сарын 27-ны өдрүүдэд тус компанийн аудитор Д.Энхтайван, Б.Галсанжамц нар ажиллаж, зураг төслийг Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцүүлэх, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдлын түвшинг сайжруулахтай холбогдох дүгнэлт, зөвлөмжийг боловсруулаа.

Энэхүү тайланг "Кеаро" ХХК-ийн захиалга, санхүүжилтээр гүйцэтгэсэн ба ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй "Этүгэн тулгат консалтинг" ХХК-ийн аудитор, мэргэжилтэн нар хараат бус байдлаар ажилласан, захиалагч байгууллагын зүгээс аливаа хэлбэрээр хувийн сонирхлоор оролцоогүй, зөвхөн мэргэжилтнүүдийг холбогдох мэдээллээр хангаж, хамтран ажилласан тул захиалагч байгууллага нь энэхүү тайланд тусгагдсан мэдээлэл, зөвлөмж болон хэвлэлийн алдаанд хариуцлага хүлээхгүй болно.

Судалгааны тайланд тусгагдсан зөвлөмж нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудитын багийн гишүүн аудитор нарын тусгай мэдлэг, ажлын туршлага болон бусад баримт бичигт үндэслэн боловсруулагдсан бөгөөд уг тайланд тусгагдсан зөвлөмжийг аль нэг этгээдийг буруутгах буюу хуулийн хариуцлага хүлээлгэх нотлох баримт болгон ашиглахгүй байвал зохих бөгөөд захиалагч болон зураг төсөл зохиогчийн зүгээс уг тайланд тусгагдсан зөвлөмжийг заавал хэрэгжүүлэх үүрэг даалгавар хэлбэрээр ашиглах үүрэггүй, замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшинг сайжруулахтай холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбогдох асуудлыг харилцан зөвшилцөх хэлбэрээр шийдвэрлэх нь зүйтэй.

Тус зөвлөх үйлчилгээ нь авто замын нарийвчилсан зураг төслийг боловсруулах шатанд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах, авто замын зураг төслийг боловсруулж, батлуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх чиглэлээр авто замын зураг төслийн аудит хийх шатлалын 3 дугаар шатны аудитыг хийсэн ба энэхүү тайланд тусгагдсан зөвлөмж, шүүмжийн хүрээнд замын хөдөлгөөн зохион байгуулалтын нарийвчилсан зураг төслийг зохиох, түүнчлэн барилгын ажлын үед аргачлал хэлбэрээр ашиглах, бусад байгууллага, албан тушаалтантай харилцан зөвшилцөх буюу захиалагчийн зүгээс зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг шалгахад ашиглах боломжтой юм.

Энэхүү тайланд тусгагдсан зөвлөмжийг авто замын хөдөлгөөн зохион байгуулалтын нарийвчилсан зураг төслийг илүү сайжруулах зорилгоор ашиглах ба барилгын ажлын явцад /IV шатны аудит/ болон ашиглалтын дараах /V шатны/ аудитуудыг хийлгэснээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх, захиалагч болон төсөл хэрэгжүүлэгчдийн хооронд, эсхүл замын хөдөлгөөнд оролцогч, орон нутгийн иргэд, бусад этгээдийн хооронд үүсч болзошгүй зөрчилдөөнийг шийдвэрлэх, зам тээврийн осол хэрэг үйлдэгдэх зэрэг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх боломжтой болохыг мөн дурьдах нь зүйтэй.

2.Төслийн тодорхойлолт

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийлгэхээр ирүүлсэн авто замын зураг төслийн байршил нь Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас зүүн урагш чиглэлд, Алтан овоо, Шилийн богд зэрэг аялал жуулчлалын бүс нутгийн дамжин, Баруун-Урт-Бичигт чиглэлийн А2002 хатуу хучилттай авто замтай нийлэх уулзвар хүртэл үргэлжилж байна.

Зураг 1.Төслийн байршил



Уг төсөл нь Сүхбаатар аймгийн Дарьганга, Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрээс эхэлж байгаа тул уг замаар зорчих үед Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан "суурин газрын гаднах зам"-д мөрдөгдөх хөдөлгөөний журмыг баримтлах ба "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 зам, замын байгууламжийн норм ба дүрмийн 1.1 дүгээр хүснэгтийн 2А буюу "Хуримтлуулагч зам" тодорхойлолтод хамаарахаар байна.

Төсөл нь тал газар болон зарим хэсэгтээ хотгор гүдгэр, нугачаатай хэсгүүдийг дайран өнгөрөх ба тусгаарлах зурвасгүй 1 зорчих хэсэг, эсрэг хөдөлгөөнтэй 2 эгнээтэй, эгнээний өргөн тус бүр 3,5 метр, 50-80 км-т амрах талбайтай, эргэлтийн муруй /радиус/ хамгийн багадаа 600 метр, зорчих хэсгийн хөндлөн огтлолын налуу 2%, далангийн нийт өргөн 10 метр, хөвөөний өргөн 1,5 метр байхаар тооцоолжээ.

Төслийн хүрээнд хамаарах 136.9 км урттай хатуу хучилттай авто замд нийт 106 ширхэг төмөр бетон хоолой, 33 уулзвартай байхаар төлөвлөсөн талаар судалгааны тайланд дурьджээ.

3.Төслийн цар хүрээ

Төслийн үндэслэл нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 97 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/50 дугаар тушаал, Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №А33Т-11/25 дугаартай "Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар"-ын дагуу "Кеаро" ХХК боловсруулсан байна.

Зураг төслийг боловсруулахдаа дээр дурьдсан нөхцөл байдал, судалгааны үр дүнд үндэслэн төслийн хүрээнд хамрах авто замыг их засвар хийж, шинэчлэх хэлбэрээр геодезийн зураг төслийг боловсруулж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийг нэг маягийн хэлбэрээр дүрсэлснээс гадна зам тэмдэг, тэмдэглэлийг хүснэгтэн жагсаалт хэлбэрээр боловсруулсан тул замын хөдөлгөөн зохион байгуулалтын нарийвчилсан зураг төслийг боловсруулах үед анхаарах асуудал, санал зөвлөмжийг энэхүү тайланд тусгасан болно.

4.Аудитын үйл явц

Зам, тээврийн яамны захиалга, улсын төсвийн санхүүжилтээр хийгдэх Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Баруун-Урт-Бичигт чиглэлийн А2002 дугаартай, 136.9 км хатуу хучилттай авто замын их засварын ажлын нарийвчилсан зураг төсөлд замын хөдөлгөөний аюулгүй байдлын 3 дугаар шатны аудит буюу олон улсад "ширээний аудит" гэж нэрлэгдэх суурин хэлбэрээр, ажиглалтын болон харьцуулалтын аргыг ашиглан гүйцэтгэлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийлгэх зураг төсөл болон тайлбар бичиг, холбогдох бусад баримт бичгүүдийг шинжлэн судалж, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, норм дүрэм, стандартуудын нийцэл, замын хөдөлгөөнд оролцогчдын онцлог, цаг уурын нөхцөл байдал, байгаль орчны тогтоц, авто замын трассын хөндлөн ба дагуу огтлол, хүн амын суурьшлын болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний онцлог зэргийг харгалзан үзэж, тухайн авто замаар зорчих хөдөлгөөнд оролцогч нарын зөрчилдөөн, биет аюул зэргийг багийн гишүүдийн туршлага, бусад нөхцөл байдалд үндэслэн дүн шинжилгээг хийж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшинг сайжруулах, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн санал, зөвлөмжийг боловсруулсан болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс мөн оны 01 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд "Этүгэн тулгат консалтинг" ХХК-ийн албан өрөөнд зохих сургалтад хамрагдсан багийн 2 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, тухайн авто зам хэрэглэгчдийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй зураг төслийн алдаа дутагдлыг илрүүлэх, тэдгээрт нөлөөлж болзошгүй шийдэл ба авто замын шинж чанар, биет аюул болон хөдөлгөөний зөрчилдөөн, эрсдэл хаана байгаа болон аль хөдөлгөөнд оролцогчид илүү эрсдэлтэй болох, уг эрсдэл чухам хэдий үед илүү идэвхижих магадлалтай зэргийг шинжлэн судалж,

тэдгээрийг засч залруулах /эрсдлийг арилгах буюу бууруулах/ боломжит хувилбаруудыг боловсруулан энэхүү тайланд зөвлөмж хэлбэрээр тусгасан болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудитын багийн гишүүдийн зүгээс зураг төслийг илүү нарийвчилж, нэмэлт зардал багатай шийдлүүдийг энэхүү тайлангийн зөвлөмж хэлбэрээр хүргүүлж байгаа бөгөөд уг зөвлөмжид тусгагдсан арга хэмжээний саналыг "Бүрэн зөвшөөрөх", "Хэсэгчлэн зөвшөөрөх", "Татгалзах" /энэ тохиолдолд эрсдлийг захиалагч, төсөл хэрэгжүүлэгч хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ/ аль нэг шийдвэрийг гаргана.

Тайлангийн зөвлөмжид тусгах шаардлагагүй, өөрөөр хэлбэл зураг төсөлд тусгасан хэлбэрээр хэрэгжүүлснээр эрсдэл үүсэхгүй боловч барилгын ажлын явцад энэхүү тайланд тусгагдсан байдлаар хэрэгжүүлсэн тохиолдолд төсвийг тодорхой хэмжээнд хэмнэх боломжтой шийдлүүдийг мөн санал болгосон болно. Үүнд:

1.Хатуу хучилттай авто зам болон шороон /хөрсөн/ хучилттай хэсэгтэй огтлолцсон бэлчирт Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 3.1 "Гол зам" тэмдгийг байрлуулсан ба уг уулзвараас тодорхой зайд мөн дүрмийн хавсралтын 3.3.а, 3.3.б, 3.3.в "Туслах зам нийлнэ" тэмдэг байрлуулсан байх тул уг хэсэг дэх 3.1 "Гол зам" тэмдгийг зураг төслөөс хасах буюу барилгын ажлын явцад захиалагч болон гүйцэтгэгчтэй зөвшилцөж, байрлуулахгүй байх;

2.Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох зүйл, хэсэгт тээврийн хэрэгслийн гүйцэж түрүүлэх үйлдлийг хориглосон зохицуулалтууд тусгагдсан байдаг тул хамгийн их дагуу эргэлтийн муруй /радиус/ 600 метрээс харьцангуй их радиус, хотгор гүдгэрийн онцлог зэрэг "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS 4596:2014 стандартын 4.3.24 дэх хэсэгт зааснаас бусад газруудад тавигдсан уг дүрмийн 1 дүгээр хавсралтын 2.20 "Гүйцэж түрүүлэх хориотой" болон 2.21 "Гүйцэж түрүүлэх хорионы төгсгөл" тэмдгүүдийг зураг төслөөс хасах барилгын ажлын явцад захиалагч болон гүйцэтгэгчтэй зөвшилцөж, байрлуулахгүй байх;

3.Зорчих хэсгийн тэнхлэг дэх Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2 дугаар хавсралтын 1.5 тэмдэглэлийг "Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4759:2014 стандартын А хавсралтын 1 дүгээр хүснэгтийн 1.5-д тусгагдсаны дагуу 3 ба 9 метрийн харьцаатайгаар, замын аюултай хэсгийг тэмдэглэсэн үргэлжилсэн зураас хүртэлх зайд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2 дугаар хавсралтын 1.6 тэмдэглэлийг /3 хүртэл давтамжтайгаар/, "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS 4596:2014 стандартын Е хавсралтын 5 дугаар зурагт тусгасны дагуу дээрх харьцааг эсрэгээр буюу 9 ба 3 харьцаатайгаар байрлуулах;

4.Замын хөдөлгөөнд оролцогч нарыг мэдээлэлжүүлэх зорилгоор шороон замын уулзвар /орц, гарц/ бүр дээр 5.34.а, 5.34.б "Чигийн заалт" тэмдгүүдийг тухай бүр, бичиглэлийн том үсгийн өндөр /h/-ийг "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4597:2014 стандартын 5.9 дэх хэсэг, D хавсралтын 16 дугаар хүснэгтэд нийцүүлэн, 200 мм хэмжээтэй байхаар хэрэглэх, түүнчлэн дээрх стандартын 5.3 дахь хэсэгт заасны дагуу суурин газар, эсхүл обьектийн албан ёсны нэршлийг монгол хэлээр крилл үсгээр, англи хэлээр, эсхүл латин үсгээр галиглаж /англи хэл, латин үсгээр бичих үед дээрх стандартын 5.11 дэх хэсэгт заасны дагуу

крилл үсгийн өндрөөс бага байхыг анхаарах/ давхар тэмдэглэхээр тооцож, уг нэг бүрчлэн хийгдэх тэмдгийн хэмжээг тохируулан байрлуулах зэрэг болно.

Зураг төсөлд тусгагдсан, ялангуяа авто замын хэрэглэгч буюу хөдөлгөөнд оролцогчдын зөрчилдөөн үүсэх, эсхүл аюул бүхий хэсгүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын нэмэлт тоноглол, зохих тэмдэг тэмдэглэл байрлуулах талаарх зөвлөмжийг тухайн хэсэгт үүсч болзошгүй эрсдлийн түвшинтэй уялдуулан тусгасан тул уг зөвлөмжийг захиалагч болон холбогдох этгээдүүдэд танилцуулж, зохих шийдлийг гаргах нь зүйтэй.

5.Дүгнэлт /дүн шинжилгээ хийсэн хувилбарууд/

Төсөлд хамрагдах авто замаар хөдөлгөөнд оролцогч нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан "суурин газрын гаднах зам"-д мөрдөгдөх хөдөлгөөний журмын баримтлах ба "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 зам, замын байгууламжийн норм ба дүрмийн 1.1 дүгээр хүснэгтийн 2А буюу "Хуримтлуулагч зам" тодорхойлолтод хамаарахаар байна.

Авто зам нь ихэвчлэн тал газар болон зарим хэсэгтээ бага зэргийн хотгор гүдгэр, нугачаатай хэсгүүдийг дайран өнгөрөх ба тусгаарлах зурвасгүй 1 зорчих хэсэг, эсрэг хөдөлгөөнтэй 2 эгнээтэй, эгнээний өргөн тус бүр 3,5 метр, 50-80 км-т амрах талбайтай, эргэлтийн муруй /радиус/ хамгийн багадаа 600 метр, зорчих хэсгийн хөндлөн огтлолын налуу 2%, далангийн нийт өргөн 10 метр, хөвөөний өргөн 1,5 метр байхаар тооцоолсон, замын тэмдэг, тэмдэглэлийн хэмжээ, холбогдох тэмдгийн дэвсгэр өнгө /цэнхэр/-ний сонголт, шаардлагатай хэсгүүдэд аюулгүй байдлын тоног төхөөрөмжийг төлөвлөсөн зэрэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын хувьд одоо ашиглагдаж буй авто замын нөхцөл байдлын хувьд Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, норм дүрэм, стандартад нийцсэн гэж дүгнэж байна.

Замын хөдөлгөөн зохион байгуулалтын нарийвчилсан зураг төсөл буюу замын тэмдэг, тэмдэглэл зэрэг хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, аюулгүй байдлын бусад тоног төхөөрөмжийг тухайн цэг тус бүрт байрлуулахаар харуулсан байх бөгөөд энэхүү тайлангийн зөвлөмжид тусгагдсан асуудлыг захиалагч болон төсөл хэрэгжүүлэгчдийн зүгээс хэлэлцэж, хөдөлгөөн зохион байгуулалтын нарийвчилсан зураг төсөлд өөрчлөлт оруулах буюу барилгын ажлын явцад нэмж тусгах байдлаар хэрэгжүүлэх боломжтой.

6.Дүгнэлтийн хүрээнд өгөх зөвлөмж /бага хэмжээний төсөв шаардагдах/

1.Хатуу хучилттай авто зам болон шороон замууд нэг түвшинд огтлолцсон Т хэлбэрийн уулзваруудад Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.29.в "Эргэх чиг" тэмдгийг хажуугаас нийлэх замын эсрэг талд, мөн дүрмийн 3.4 "Зам тавьж өгнө" тэмдгийн доор 4.1.е "Баруун буюу зүүн гар тийш явна" тэмдгийг /Зургийн дугаар 26-02.01/ тус тус нэмж байрлуулах;

2.Нэг цэгт зэргэлдээ хэлбэрээр байгуулах амрах талбай буюу зогсоолын хэсэг /Зургийн дугаар 26-02.03/-т Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 2.24 "Хурдны дээд хязгаарлал" тэмдгийг "60" ба "40" гэсэн үзүүлэлтээр өөрчлөн /зураг төсөлд тусгагдсан "30" гэснийг "40" болгон өөрчилж, "60" тэмдгийг 100 метр зайд нэмж/ байрлуулах ба уг хэсэгт "Хурд сааруулагч. Хэрэглэх дүрэм, жишиг зургийн цомог. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5968:2024 стандартын 6 дахь

хэсэг /15 дугаар нүүр/-т заасан "өргөн" хурд сааруулагч хэлбэрээр байрлуулах, мөн зогсоол ба зорчих хэсгийг тусгаарласан өндөрсгөсөн хашлага дээр мөн дүрмийн 4.2.в "Саадыг баруун буюу зүүн гар талаар тойрч гарна" тэмдгийг 2.1.б босоо тэмдэглэл /улаан цагаан/-ийн хамт байрлуулах;

3.Орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс гарсан санал болон судалгааны үр дүн зэрэг нөхцөл байдалд үндэслэн, малчин айл өрхүүд авто замын ойролцоо /ялангуяа авто замын 2 талаар/ нутаглаж, зусах зэргээр хүн, малын хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.22 "Мал тууж гарах газар" тэмдэг байрлуулахаар төлөвлөсөн хэсгүүд /Зургийн дугаар: 26-02.04/-эд уг тэмдгүүдийн хоорондын зайг 300 метр болгон нэмэгдүүлж, тэмдгүүдээс 2 тийш 2000 метрээс багагүй /байгалийн тогтоц зэргийг харгалзан/ зайд, зорчих хэсгийн 2 талаар "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS 4596:2014 стандартын 7.2.5, 7.2.6 дахь хэсэгт заасан /2-р бүлгийн торон/ хашилт байрлуулах;

4.Зорчих хэсгийн зөвхөн нэг талд байрласан, олон тооны автомашин зогсоох зориулалт бүхий талбай буюу зогсоолын хэсэг /Зургийн дугаар 26-02.05/-т энэхүү зөвлөмжийн 3 дахь хэсэгт зааснаас гадна орох, гарах хэсгийг тодорхой ойлгогдохуйц болгох зорилгоор Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 2.1 "Орох хориотой" тэмдгийг нэмж байрлуулах;

5.Төслийн хамрах хүрээний төгсгөл буюу Баруун-Урт-Бичигт чиглэлийн А2002 хатуу хучилттай авто замтай нэг түвшинд огтлолцох бэлчир хэсэг /Зургийн дугаар 26-02.06/-ийн аюулгүй байдлын түвшинг сайжруулах зорилгоор уг хэсэгт тавигдах Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 5.33.а "Чигийн урьдчилсан заалт" тэмдгийн дэвсгэрийн өнгийг цэнхэр өнгөөр сонгож, бичиглэл болон дүрслэлийг өөрчлөх ба зорчих хэсгүүдийн бэлчирээс 200 метр зайд мөн дүрмийн 3.2 "Гол замын төгсгөл" тэмдгийг 3.4 "Зам тавьж өгнө" болон 7.1.а "Обьект хүртэлх зай" нэмэлт тэмдгийн хамт, түүнчлэн уг тэмдэг байрлуулсан зорчих хэсгийн эсрэг талд мөн дүрмийн 3.1 "Гол зам" тэмдэг, мөн энэхүү зөвлөмжийн 1 дэх хэсэгт тусгагдсан Т хэлбэрийн уулзварт нэмэлтээр хийгдэх 1.29.в "Эргэх чиг" тэмдгийг төслийн авто зам нийлэх хэсгийн эсрэг талд, мөн дүрмийн 3.4 "Зам тавьж өгнө" тэмдгийн доор 4.1.е "Баруун буюу зүүн гар тийш явна" тэмдгүүдийг тус тус байрлуулах;

6.Энэхүү зөвлөмжийн 5 дахь хэсэгт заасантай уялдуулан, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дэвсгэр дэх төслийн эхлэл хэсэг /Зургийн дугаар 26-02.07/-ээс 200 метр зайд мөн дүрмийн 3.2 "Гол замын төгсгөл" тэмдгийг 3.4 "Зам тавьж өгнө" болон 7.1.а "Обьект хүртэлх зай" нэмэлт тэмдгийн хамт, түүнчлэн уг тэмдэг байрлуулсан зорчих хэсгийн эсрэг талд мөн дүрмийн 3.1 "Гол зам" тэмдэг, тухайн хэсгээс сумын төв хүрэх чиглэлд буюу тус сумын төвийн бодит эхлэл хэсэгт 5.3 "Суурин газрын эхлэл" болон зорчих хэсгийн эсрэг талд 5.4 суурин газрын төгсгөл тэмдгүүдийг тус тус байрлуулах;

7.Нэг маягийн зураг төсөлд тусгагдсан, хөндлөн огтлол нь зорчих хэсгээс дээшээ буюу доошоо 3 метрээс өндөр далантай /Зургийн дугаар 26-02.08/, ялангуяа огцом эргэлт бүхий хэсгүүдэд "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS 4596:2014 стандартын 7.2.1 дэх хэсэгт заасан /1-р бүлгийн туузан/ хашилтыг мөн стандартын G хавсралтын 2 дугаар зурагт харуулсны дагуу, түүнчлэн "Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага"

MNS 4759:2014 стандартын 4.2.3 дахь хэсэгт заасны дагуу зорчих хэсгийн баруун гар талд улаан, зүүн гар талд цагаан өнгөтэйгөөр хоорондоо 4 метрийн зайд гэрэл ойлгууртайгаар байрлуулах зэрэг болно.

7.Дүгнэлтийн хүрээнд өгөх зөвлөмж /их хэмжээний төсөв шаардагдах хувилбар/

1.Төслийн хамрах хүрээний төгсгөл буюу Баруун-Урт-Бичигт чиглэлийн А2002 хатуу хучилттай авто замтай нэг түвшинд огтлолцох бэлчир хэсэг /Зургийн дугаар 26-02.06/-ийн аюулгүй байдлын түвшинг сайжруулах зорилгоор уг хэсэгт "Авто замын тойрог уулзвар. Зураг төсөллөх дүрэм" MNS GOST 70555:2024-ийн 2 дугаар хүснэгт /8 дугаар хуудас/-ийн 1Г-ГЗ-ЗХГ-2-90 Төв замын сүлжээн дэх гол зам бөгөөд зорчих хэсэг нь зааглагдаагүй, хөдөлгөөний 2 зурвастай ангилал, зэрэглэлд хамаарах авто замын дунд зэргийн диаметртэй тойрог уулзварт тавигдах шаардлагыг хангасан үед уг дүрэм болон холбогдох бусад норм дүрэм, стандартад нийцүүлэн тойрог уулзвар хэлбэрээр төлөвлөхийг зөвлөж байна.

8.Эрэмбэ ба дараалал

Төслийн хүрээнд хамаарах авто замын зураг төсөлд аудит хийсэн тайланд үндэслэн өгсөн зөвлөмжүүдийн хамгийн бага төсөв шаардагдах хувилбарыг сонгох нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшинг хангалттай хэмжээгээр нэмэгдүүлэх буюу өртөг, өгөөжийн шинжилгээгээр илүү ашигтай хувилбар гэж үзсэн тул энэхүү зөвлөмжид тусгагдсан бага өртөг бүхий саналуудыг зураг төсөлд тусгах нь зүйтэй.

9.Зөвлөмжийн хариу үзүүлэлт

Зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний тайланг авто замын зураг төслийн баримт бичгийн бүрдэлд оруулж, зохих журмын дагуу архивын нэгж болгон хадгалах шаардлагатай болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

УЛААНБААТАР ХОТ
ЭТҮГЭН ТУЛГАТ КОНСАЛТИНГ ХХК
9021 1120
6761012 6716368

Д.ЭНХТАЙВАН

Б.ГАЛСАНЖАМЦ

ЭТҮГЭН ТУЛГАТ КОНСАЛТИНГ ХХК 9021091100 6761062 СБТ16368

ЗУРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Зургийн дугаар: 26-02.01. Хатуу хучилттай болон шороон замын огтлолцох бэлчирийг Т хэлбэрийн уулзварын зохион байгуулалтын бүдүүвч



Зургийн дугаар: 26-02.02. Амрах талбай орчмын хөдөлгөөн зохион байгуулалтын бүдүүвч



Зургийн дугаар: 26-02.03. Мал тууж гарах газар буюу мал бүхий иргэд, хот айл орчмын хөдөлгөөн зохион байгуулалтын бүдүүвч



Зургийн дугаар: 26-02.04. Амрах талбай хэсгийн зохион байгуулалт /2 дахь/



Зургийн дугаар: 26-02.05. Хатуу хучилттай авто замтай огтолцох хэсгийн зохион байгуулалтын бүдүүвч



Зургийн дугаар: 26-02.06. Төслийн эхлэл хэсгийн зохион байгуулалтын бүдүүвч



Зургийн дугаар: 26-02.07. Өндөр далан бүхий хэсгийн зохион байгуулалтын бүдүүвч



---oOo---

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР

2026 оны .... дугаар сарын ...-ны өдөр

д/д	Зургийн дугаар	Зөвлөмжийн агуулга	Төслийн байршил	Эрсдлийн түвшин
1.	26-02.01	Хатуу хучилттай авто зам болон шороон замууд нэг түвшинд огтлолцсон Т хэлбэрийн уулзварууд /Зургийн дугаар 26-02.01/-ад Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.29.в “Эргэх чиг” тэмдгийг хажуугаас нийлэх замын эсрэг талд, мөн дүрмийн 3.4 “Зам тавьж өгнө” тэмдгийн доор 4.1.е “Баруун буюу зүүн гар тийш явна” тэмдгийг /Зургийн дугаар 26-02.01/ тус тус нэмж байрлуулах	ПК0+980, ПК3+160, ПК7+260, ПК9+060, ПК11+060, ПК12+700, ПК13+3200, ПК15+060, ПК136+960	Дунд зэргийн эрсдэл /эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/
2.	26-02.02	Нэг цэгт зэргэлдээ хэлбэрээр байгуулах амрах талбай буюу зогсоолын хэсэг /Зургийн дугаар 26-02.02/-т Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 2.24 “Хурдны дээд хязгаарлал” тэмдгийг “60” ба “40” гэсэн үзүүлэлтээр өөрчлөн /зураг төсөлд тусгагдсан “30” гэснийг “40” болгон өөрчилж, “60” тэмдгийг 100 метр зайд нэмж/ байрлуулах ба уг хэсэгт “Хурд сааруулагч. Хэрэглэх дүрэм, жишиг зургийн цомог. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5968:2024 стандартын 6 дахь хэсэг /15 дугаар нүүр/-т заасан “өргөн” хурд сааруулагч хэлбэрээр байрлуулах, мөн зогсоол ба зорчих хэсгийг тусгаарласан өндөрсгөсөн хашлага дээр мөн дүрмийн 4.2.в “Саадыг баруун буюу зүүн гар талаар тойрч гарна” тэмдгийг 2.1.б босоо тэмдэглэл /улаан цагаан/-ийн хамт байрлуулах	ПК26+140, ПК81+800, ПК112+800	Дунд зэргийн эрсдэл /эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/

3.	26-02.03	Орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс гарсан санал болон судалгааны үр дүн зэрэг нөхцөл байдалд үндэслэн, малчин айл өрхүүд авто замын ойролцоо /ялангуяа авто замын 2 талаар/ нутаглаж, зусах зэргээр хүн, малын хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.22 "Мал тууж гарах газар" тэмдэг байрлуулахаар төлөвлөсөн хэсгүүд /Зургийн дугаар: 26-02.03/-эд уг тэмдгүүдийн хоорондын зайг 300 метр болгон нэмэгдүүлж, тэмдгүүдээс 2 тийш 2000 метрээс багагүй /байгалийн тогтоц зэргийг харгалзан/ зайд, зорчих хэсгийн 2 талаар "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS 4596:2014 стандартын 7.2.5, 7.2.6 дахь хэсэгт заасан /2-р бүлгийн торон/ хашилт байрлуулах	ПК3+800, ПК24+800, ПК40+100, ПК41+400, ПК54+700, ПК97+900, ПК118+900, ПК123+160	Дунд зэргийн эрсдэл /эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/
4.	26-02.04	Зорчих хэсгийн зөвхөн нэг талд байрласан, олон тооны автомашин зогсоох зориулалт бүхий талбай буюу зогсоолын хэсэг /Зургийн дугаар 26-02.04/-т энэхүү зөвлөмжийн 3 дахь хэсэгт зааснаас гадна орох, гарах хэсгийг тодорхой ойлгогдохуйц болгох зорилгоор Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 2.1 "Орох хориотой" тэмдгийг нэмж байрлуулах	ПК58+500	Өндөр эрсдэл /хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр гэмтэл учрах/
5.	26-02.05	Төслийн хамрах хүрээний төгсгөл буюу Баруун-Урт-Бичигт чиглэлийн А2002 хатуу хучилттай авто замтай нэг түвшинд огтлолцох бэлчир хэсэг /Зургийн дугаар 26-02.06/-ийн аюулгүй байдлын түвшинг сайжруулах зорилгоор уг хэсэгт тавигдах Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 5.33.а "Чигийн урьдчилсан заалт" тэмдгийн дэвсгэрийн өнгийг цэнхэр өнгөөр сонгож, бичиглэл болон дүрслэлийг өөрчлөх ба зорчих хэсгүүдийн бэлчирээс 200 метр зайд мөн дүрмийн 3.2 "Гол замын төгсгөл" тэмдгийг 3.4 "Зам тавьж өгнө" болон 7.1.а "Обьект хүртэлх зай" нэмэлт тэмдгийн хамт, түүнчлэн уг тэмдэг байрлуулсан зорчих хэсгийн эсрэг талд мөн дүрмийн 3.1 "Гол зам" тэмдэг, мөн энэхүү зөвлөмжийн 1 дэх хэсэгт тусгагдсан Т хэлбэрийн уулзварт нэмэлтээр хийгдэх 1.29.в "Эргэх чиг" тэмдгийг төслийн авто зам нийлэх хэсгийн эсрэг талд, мөн дүрмийн 3.4 "Зам тавьж өгнө" тэмдгийн доор 4.1.е "Баруун буюу зүүн гар тийш явна" тэмдгүүдийг тус тус байрлуулах;	ПК136+960	Дунд зэргийн эрсдэл /эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/
6.	26-02.06	Энэхүү зөвлөмжийн 5 дахь хэсэгт заасантай уялдуулан, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дэвсгэр дэх төслийн эхлэл хэсэг /Зургийн	ПК0+000	Дунд зэргийн эрсдэл

		дугаар 26-02.07/-ээс 200 метр зайд мөн дүрмийн 3.2 “Гол замын төгсгөл” тэмдгийг 3.4 “Зам тавьж өгнө” болон 7.1.а “Обьект хүртэлх зай” нэмэлт тэмдгийн хамт, түүнчлэн уг тэмдэг байрлуулсан зорчих хэсгийн эсрэг талд мөн дүрмийн 3.1 “Гол зам” тэмдэг, тухайн хэсгээс сумын төв хүрэх чиглэлд буюу тус сумын төвийн бодит эхлэл хэсэгт 5.3 “Суурин газрын эхлэл” болон зорчих хэсгийн эсрэг талд 5.4 суурин газрын төгсгөл тэмдгүүдийг тус тус байрлуулах		/эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/
7.	26-02.07	Нэг маягийн зураг төсөлд тусгагдсан, хөндлөн огтлол нь зорчих хэсгээс дээшээ буюу доошоо 3 метрээс өндөр далантай /Зургийн дугаар 26-02.07/, ялангуяа огцом эргэлт бүхий хэсгүүдэд “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартын 7.2.1 дэх хэсэгт заасан /1-р бүлгийн туузан/ хашилтыг мөн стандартын G хавсралтын 2 дугаар зурагт харуулсны дагуу, түүнчлэн “Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4759:2014 стандартын 4.2.3 дахь хэсэгт заасны дагуу зорчих хэсгийн баруун гар талд улаан, зүүн гар талд цагаан өнгөтэйгөөр хоорондоо 4 метрийн зайд гэрэл ойлгууртайгаар байрлуулах	-	Өндөр эрсдэл /хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр гэмтэл учрах/

---oOo---

“ЭТҮГЭН ТУЛГАТ КОНСАЛТИНГ” ХХК-ИЙН БОЛОВСРУУЛСАН, №26-02 ДУГААРТАЙ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

д/д	Зургийн дугаар	Зөвлөмжийн агуулга	Төслийн байршил	Эрсдлийн түвшин	Зураг төсөл зохиогч /гүйцэтгэгч/-ийн хариу
1.	26-02.01	Хатуу хучилттай авто зам болон шороон замууд нэг түвшинд огтлолцсон Т хэлбэрийн уулзварууд /Зургийн дугаар 26-02.01/-ад Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.29.б “Эргэх чиг” тэмдгийг хажуугаас нийлэх замын эсрэг талд, мөн дүрмийн 3.4 “Зам тавьж өгнө” тэмдгийн доор 4.1.е “Баруун буюу зүүн гар тийш явна” тэмдгийг /Зургийн дугаар 26-02.01/ тус тус нэмж байрлуулах	ПК0+980, ПК3+160, ПК7+260, ПК9+060, ПК11+060, ПК12+700, ПК13+3200, ПК15+060, ПК136+960	Дунд зэргийн эрсдэл /эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/	Зөвлөмжийн дагуу зураг төсөлд засварыг хийж тусгав. /Зураг төслийн “Замын байгуулалт” болон “Тоноглол” хэсгээс үзнэ үү/
2.	26-02.02	Нэг цэгт зэргэлдээ хэлбэрээр байгуулах амрах талбай буюу зогсоолын хэсэг /Зургийн дугаар 26-02.02/-т Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 2.24 “Хурдны дээд хязгаарлал” тэмдгийг “60” ба “40” гэсэн үзүүлэлтээр өөрчлөн /зураг төсөлд тусгагдсан “30” гэснийг “40” болгон өөрчилж, “60” тэмдгийг 100 метр зайд нэмж/ байрлуулах ба уг хэсэгт “Хурд сааруулагч. Хэрэглэх дүрэм, жишиг зургийн цомог. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5968:2024 стандартын 6 дахь хэсэг /15 дугаар нүүр/-т заасан “өргөн” хурд сааруулагч хэлбэрээр байрлуулах, мөн зогсоол ба зорчих хэсгийг тусгаарласан өндөрсгөсөн хашлага дээр мөн дүрмийн 4.2.в “Саадыг баруун буюу зүүн гар талаар тойрч гарна” тэмдгийг 2.1.б босоо тэмдэглэл /улаан цагаан/-ийн хамт байрлуулах	ПК26+140, ПК81+800, ПК112+800	Дунд зэргийн эрсдэл /эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/	Зөвлөмжийн дагуу зураг төсөлд засварыг хийж тусгав. /Зураг төслийн “Замын байгуулалт” болон “Тоноглол” хэсгээс үзнэ үү/
3.	26-02.03	Орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс гарсан санал болон судалгааны үр дүн зэрэг нөхцөл байдалд үндэслэн, малчин айл өрхүүд авто замын	ПК3+800, ПК24+800, ПК40+100,	Дунд зэргийн эрсдэл	Зөвлөмжийн дагуу зураг төсөлд засварыг хийж тусгав. /Зураг төслийн “Замын байгуулалт” болон

		ойролцоо /ялангуяа авто замын 2 талаар/ нутаглаж, зусах зэргээр хүн, малын хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.22 “Мал тууж гарах газар” тэмдэг байрлуулахаар төлөвлөсөн хэсгүүд /Зургийн дугаар: 26-02.03/-эд уг тэмдгүүдийн хоорондын зайг 300 метр болгон нэмэгдүүлж, тэмдгүүдээс 2 тийш 2000 метрээс багагүй /байгалийн тогтоц зэргийг харгалзан/ зайд, зорчих хэсгийн 2 талаар “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартын 7.2.5, 7.2.6 дахь хэсэгт заасан /2-р бүлгийн торон/ хашилт байрлуулах	ПК41+400, ПК54+700, ПК97+900, ПК118+900, ПК123+160	/эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/	“Тоноглол” хэсгээс үзнэ үү/ Торон хашилтыг ажлын тоо хэмжээ болон тайлбар бичигт тусгав.
4.	26-02.04	Зорчих хэсгийн зөвхөн нэг талд байрласан, олон тооны автомашин зогсоох зориулалт бүхий талбай буюу зогсоолын хэсэг /Зургийн дугаар 26-02.04/-т энэхүү зөвлөмжийн 3 дахь хэсэгт зааснаас гадна орох, гарах хэсгийг тодорхой ойлгогдохуйц болгох зорилгоор Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 2.1 “Орох хориотой” тэмдгийг нэмж байрлуулах	ПК58+500	Өндөр эрсдэл /хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр гэмтэл учрах/	Зөвлөмжийн дагуу зураг төсөлд засварыг хийж тусгав. /Зураг төслийн “Замын байгуулалт” болон “Тоноглол” хэсгээс үзнэ үү/
5.	26-02.05	Төслийн хамрах хүрээний төгсгөл буюу Баруун-Урт-Бичигт чиглэлийн А2002 хатуу хучилттай авто замтай нэг түвшинд огтлолцох бэлчир хэсэг /Зургийн дугаар 26-02.05/-ийн аюулгүй байдлын түвшинг сайжруулах зорилгоор уг хэсэгт тавигдах Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 5.33.а “Чигийн урьдчилсан заалт” тэмдгийн дэвсгэрийн өнгийг цэнхэр өнгөөр сонгож, бичиглэл болон дүрслэлийг өөрчлөх ба зорчих хэсгүүдийн бэлчирээс 200 метр зайд мөн дүрмийн 3.2 “Гол замын төгсгөл” тэмдгийг 3.4 “Зам	ПК136+960	Дунд зэргийн эрсдэл /эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/	Зөвлөмжийн дагуу зураг төсөлд засварыг хийж тусгав. /Зураг төслийн “Замын байгуулалт” болон “Тоноглол” хэсгээс үзнэ үү/ Манай төлөвлөж байгаа зам нь хөдөлгөөний эрчим бага аялал жуулчлалын зориулалт бүхий зам учир 3.4 “туслах зам” тэмдэг тавьсан. Харин Баруун-Урт- Эрдэнэцагаан чиглэлийн зам нь улсын чанартай

		тавьж өгнө” болон 7.1.а “Обьект хүртэлх зай” нэмэлт тэмдгийн хамт, түүнчлэн уг тэмдэг байрлуулсан зорчих хэсгийн эсрэг талд мөн дүрмийн 3.1 “Гол зам” тэмдгийг тус тус байрлуулах			зам учир тус замд 3.1 “Гол зам” тэмдэг байрлуулсан.
6.	26-02.06	Энэхүү зөвлөмжийн 6 дахь хэсэгт заасантай уялдуулан, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дэвсгэр дэх төслийн эхлэл хэсэг /Зургийн дугаар 26-02.06/-ээс 200 метр зайд мөн дүрмийн 3.2 “Гол замын төгсгөл” тэмдгийг 3.4 “Зам тавьж өгнө” болон 7.1.а “Обьект хүртэлх зай” нэмэлт тэмдгийн хамт, түүнчлэн уг тэмдэг байрлуулсан зорчих хэсгийн эсрэг талд мөн дүрмийн 3.1 “Гол зам” тэмдэг, тухайн хэсгээс сумын төв хүрэх чиглэлд буюу тус сумын төвийн бодит эхлэл хэсэгт 5.3 “Суурин газрын эхлэл” болон зорчих хэсгийн эсрэг талд 5.4 суурин газрын төгсгөл тэмдгүүдийг тус тус байрлуулах	ПК0+000	Дунд зэргийн эрсдэл /эд матер-иалын хохирол, хөнгөн гэмтэл/	Зөвлөмжийн дагуу зураг төсөлд засварыг хийж тусгав. /Зураг төслийн “Замын байгуулалт” болон “Тоноглол” хэсгээс үзнэ үү/
7.	26-02.07	Нэг маягийн зураг төсөлд тусгагдсан, хөндлөн огтлол нь зорчих хэсгээс дээшээ буюу доошоо 3 метрээс өндөр далантай /Зургийн дугаар 26-02.07/, ялангуяа огцом эргэлт бүхий хэсгүүдэд “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартын 7.2.1 дэх хэсэгт заасан /1-р бүлгийн туузан/ хашилтыг мөн стандартын G хавсралтын 2 дугаар зурагт харуулсны дагуу, түүнчлэн “Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4759:2014 стандартын 4.2.3 дахь хэсэгт заасны дагуу зорчих хэсгийн баруун гар талд улаан, зүүн гар талд цагаан өнгөтэйгөөр хоорондоо 4 метрийн зайд гэрэл ойлгуур тайгаар байрлуулах	-	Өндөр эрсдэл /хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр гэмтэл учрах/	Зөвлөмжийн дагуу зураг төсөлд засварыг хийж тусгав. /Зураг төслийн “Замын байгуулалт”, “Хучилтын хийц болон нэг маягын хөндлөн огтлол” болон “Тоноглол” хэсгээс үзнэ үү/